
ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

“Дархан молор эрдэнэ” ХХК-ийн захирал..... /Т.Мөнхзул/

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ХАРАА-3” ЭЛСНИЙ УУРХАЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

(ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛИЙН ДУГААР MV-001824)

ХЯНАСАН:

Дархан –Уул аймгийн Байгаль Орчин ,Аялал Жуулчлалын Газрын
мэргэжилтэн...../А.Энхжин/

БОЛОВСРУУЛСАН:

инженер..... /Д.Болдхуяг/

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн
тайлангийн агуулга**

	хуудасны дугаар
1. Удиртгал	3
2. Төсөл хэрэгжүүлэгч “Дархан молор эрдэнэ” ХХК-ийн “Хараа-3” уурхайн төслийн товч мэдээлэл	7
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	8
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	9
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	9
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	11
7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
10. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	12
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	12
12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	13
13. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	14
14. Дүгнэлт	14

1. Удиртгал

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

“Хараа-3” элсний орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт УБТЗ-ын Салхит өртөөнөөс урагш шулуун зайгаар 2.2 км-т, Хараа голын баруун эрэгт оршино. (Хавсралт зураг №1)

АМГТХЭГ-ын ГУУКА-аас “Дархан Молор Эрдэнэ” ХХК-д 2007 оны 01 дүгээр сарын 29-нд олгосон MV-001824 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хараа-3” нэртэй талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1:100000 масштабтай байр зүйн зургийн М-48-104 нэрлэвэртэй хавтгайд оршино. Талбайн тусгай зөвшөөрлийн дугаар, байршлын солбицол, талбайн хэмжээг хүснэгт №1-1-д үзүүлэв.

Хүснэгт №1

Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн булангийн эргэлтийн цэгийн солбицол (WGS-84 эллипсоидод)		Тэгш өнцгийн солбицол (UTM тусгалд)		Талбайн хэмжээ (га)	Тусгай зөвшөөрөл олгосон огноо
		Өргөрөг	Уртраг	Х	У		
Хараа-3 элсний орд	MV-001824	1. 105° 51' 50.04"	49° 10' 56.29"	5448081.0440	562956.5480	15.92	2007/01/29
		2. 105° 51' 32.72"	49° 10' 42.11"	5447639.1799	562610.9120		
		3. 105° 51' 32.79"	49° 10' 42.69"	5447657.1062	562612.1258		
		4. 105° 51' 32.78"	49° 10' 43.35"	5447677.4845	562611.6921		
		5. 105° 51' 32.67"	49° 10' 44.17"	5447702.7806	562609.1779		
		6. 105° 51' 32.52"	49° 10' 44.81"	5447722.5092	562605.9170		
		7. 105° 51' 32.19"	49° 10' 45.69"	5447749.6075	562598.9282		
		8. 105° 51' 31.82"	49° 10' 46.44"	5447772.6823	562591.1752		
		9. 105° 51' 31.29"	49° 10' 47.28"	5447798.4996	562580.1517		
		10. 105° 51' 30.79"	49° 10' 47.90"	5447817.5302	562569.8127		
		11. 105° 51' 30.12"	49° 10' 48.59"	5447838.6834	562556.0078		
		12. 105° 51' 29.42"	49° 10' 49.21"	5447857.6681	562541.6202		
		13. 105° 51' 28.05"	49° 10' 50.29"	5447890.7039	562513.5086		
		14. 105° 51' 27.02"	49° 10' 51.01"	5447912.7011	562492.4060		
		15. 105° 51' 28.48"	49° 10' 51.91"	5447940.8277	562521.6464		
		16. 105° 51' 29.73"	49° 10' 52.82"	5447969.2150	562546.6319		
		17. 105° 51' 30.88"	49° 10' 53.84"	5448000.9763	562569.5544		
		18. 105° 51' 31.81"	49° 10' 54.89"	5448033.6135	562588.0126		
		19. 105° 51' 32.57"	49° 10' 55.93"	5448065.9030	562603.0328		
		20. 105° 51' 33.12"	49° 10' 56.95"	5448097.5267	562613.8088		
		21. 105° 51' 33.45"	49° 10' 58.04"	5448131.2614	562620.1069		
		22. 105° 51' 33.58"	49° 10' 59.17"	5448166.1853	562622.3423		
		23. 105° 51' 33.43"	49° 11' 01.19"	5448228.5279	562618.5979		
		24. 105° 51' 33.30"	49° 11' 01.91"	5448250.7314	562615.7141		
		25. 105° 51' 54.19"	49° 11' 01.91"	5448255.5473	563038.5725		

Уул зүйн байрлалаар ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт хамаарагдана.

Районы газрын гадарга нь дунд зэргийн өндөртэй уулс хоорондын жижиг толгодлог хөндий, зарим газартаа доворхог тал газрын хэлбэртэй байна.

Ордын талбайн гадаргуугийн рельеф нь тэгшивтэр, голын урсгалын дагуу урдаас, хойш чиглэсэн бага зэрэг налуу гадаргуу үүсгэсэн байдаг. Ус зүйн хувьд Төв Азийн гадагшаа урсгалтай голын ай савд багтана. Усан сүлжээний хувьд ордын районд хамгийн том гол нь өмнөөс хойш урсаж байгаа Хараа гол бөгөөд элсний Хараа-3 орд энэ голын хөндийд оршино.

Хараа голын хөндий нь нилээд өргөн 3.0-7.0 км хүрдэг ба хөндийн хамгийн өндөр цэг нь 742 м байна.

Ордын талбайн хүрээнд ямар нэг суурин газар, барилга байгууламж, тариа ногооны талбай байхгүй. Тус орд нь манай аж үйлдвэрийн төвийн бүсэд байрладаг, дэд бүтэц сайн хөгжсөн дэвсгэр нутагт оршдог.

Геологийн тогтцын хувьд Хараа элсний орд нь Хараа голын хөндийн дэнжид тархсан дунд плестоцены настай аллювийн гаралтай нэг төрлийн хурдаснаас тогтоно. Ордын элс нь Хараа голын хөндийн I дэнжид голын урсгалын дагуу урдаас хойш сунаж тогтсон ба ордын хайгуул хийсэн хэсгийн урт нь 470 м, өргөн нь 15-24 м дунджаар 16.0 м байна.

Ордыг бүрдүүлж байгаа хурдас нь бүхэлдээ голын хөндийн I дэнжийн аллювийн хурдас болох элснээс тогтох бөгөөд эдгээр нь ерөнхийдээ нэг төрлийн жигд найрлагатай, саарал, шаравтар саарал өнгөтэй, том ширхэгтэй байна.

Ордын хайгуул хийсэн хэсэг дэх элсний давхарга дотор өөр төрлийн болон онцгой ялгарах чулуулгийн үе судлууд байхгүй байна.

Ордын элсэн дэх том ширхэгт хольц буюу 5 мм-ээс том хэмжээтэй хэсэг нь 5.3-12.1%-д хэлбэлзэх ба ордын хэмжээнд дунджаар 8.8 % байна.

Ордын элс нь нэг төрлийн, тогтвортой кварц-хээрийн жоншны найрлагатай, том хэмхдэслэг хольц нь зонхилж метаморфжсон элсэн чулуу, боржин, риолит, дацитийн төрлийн чулуулаг байна.

Элс нь шаварлаг ба тоосорхог хэсэг багатай, органик хольцгүй байна

Дархан-Уул, Сэлэнгэ аймгууд, Орхон, Хараа голуудын бэлчир нутгийн геологийн судалгаа үндсэндээ ЗХУ-ын Шинжлэх ухааны академи, БНМАУ-ын Шинжлэх ухааны хорооны хамтарсан экспедицүүд 1950-аад онд байгуулагдан судалгаа явуулснаар эхлэсэн гэж үздэг.

2011 онд “Дархан Молор эрдэнэ” ХХК нь Хараа-3 элсний ордод хайгуулын ажил хийж, элс-хайрганы хольцын бодитой (В) нөөцийг 368083.7 куб.м, үүнээс 32576.9 м³ нь хайрга, 335506.8 м³ нь элс гэж тогтоосон байна.

Орд нь дэд бүтэц сайн хөгжсөн, зам харилцаа сайтай, зах зээлдээ ойрхон, бүтээгдүхүүнээ түргэн шуурхай борлуулах боломжтой орд юм.

“Хараа-3” ордын элсэнд 5 мм-с том хэмхдэст материал дундажаар 8.8% тодорхойлогдсон тул шигшин ангилах шаардлагатай юм. Элсийг уснаас олборлох учир дахин угаалт хийх шаардлагагүй юм.

Иймд “Дархан Молор-Эрдэнэ” ХХК нь уурхайн дэргэд элс шигшин ангилах тоног төхөөрөмж ГИЛ-43 (ОХУ) -ийг 2015 онд угсарч суурилуулсан .

Элсийг шигшин баяжуулахад эцсийн бүтээгдэхүүн нь барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс MNS 392-98 стандартыг бүрэн хангаж байна.

Эхний ээлжинд уурхай дээр олборлож усгүйжсэн элсийг автосамосвалаар тээвэрлэн авчирч шигшүүрийн түүхий эд хүлээн авах хайрцагт тэжээгүүрт өгнө. Элс нь эндээс тэжээгүүрийн хоолойгоор дамжин ГИЛ-43 маркийн шигшүүрт ирж ангилах төхөөрөмж нь элсийг 5мм-ээс бага 91.2%, 5мм-ээс том хэсэг 8.8% гэсэн ширхэглэлээр тус тус ангилна.

Уурхай болон үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд хэвийн найдвартай ажиллагаатай ажилласан болно..

Үйлдвэрлэлийн болон ахуйн цахилгааны хэрэглээг төвийн эрчим хүчний Дархан-Салхитын цахилгаан түгээх сүлжээнээс салаалсан Төмөр замын Салхит өртөөний 6/0.4 кВ-ийн 600кВа чадалтай трансформаторын дэд станцаас 500м урт 0.4 кВ-ийн ИЦАШ-аар салаалж авсан шугамаас авч хангаж ажилласан.

Уурхай болон үйлдвэрийн цахилгааны гол хэрэглэгчид нь үйлдвэр, жижиг механик засварын газар, цайны газар, үйлдвэрийн гэрэлтүүлэг зэрэг байв.

Уурхай ба боловсруулах цех нь нүсэр бүтэцгүй улирлын чанартай 1 ээлжээр ажилласан учир уурхай дээр овор бага вагончик юмуу энэ хэлбэрийн барилга байгууламж баригдах ба тусгайлсан дулаан хангамж шаардлагагүй юм. Мөн уурхай УБ Төмөр замын Салхит өртөөний дэргэд байгаа учир ажиллагсад гэрээсээ компаний үйлчилгээний бага оврын автобусаар ажилдаа ирж очсон. Хараа-3” элсний ордод 18 жил үйлдвэрлэл явуулах тул үйлдвэрийн болон туслах объектууд байх шаардлагатай ба ажиллагсдын хөдөлмөрлөх нөхцлийг дээд зэргээр хангах зохион байгуулалтын бүхий л арга хэмжээг авч ажилласан.

Уг ордын нөөц тогтоогдсон талбайн ойр орчим нь дэд бүтэц сайн хөгжсөн УБ ТЗ-ын Салхит өртөөний дэргэд байдаг. Иймд элс олборлож ангилах ялгах үйл ажиллагаа явуулахад нэн таатай эдийн засгийн төвлөрсөн бүсэд хамаарна.

Уурхай ба үйлдвэрийн засвар үйлчилгээг компанийн Дархан хот дахь үйлдвэр баазын механик цехээс зохицуулан гүйцэтгэнэ. Компанийн засварын цех нь бусад нэгжүүдээ суурин

болон явуулын хэлбэрээр үйлчилдэг. Энэ цехэд гүйцэтгэж чадахгүй зарим зүйлийг хийж чадахуйц газар, компаниудад захиалга, гэрээ хэлцлээр зохицуулан гүйцэтгэсэн.

Томоохон засвар үйлчилгээг үйлдвэр баазын механик цехэд хийх ба сарын графикт үйлчилгээ засварыг уурхай дээр гүйцэтгэж ажилласан.

Ажиллагсдын хоол цайг цахилгаанаар хийж ажилласан.. Мөн контор, сахиулын вагончик байр зэргийг зах зээл дэх нүүрс, утаагүй шахмал түлш, мод зэргээр энгийн ахуйн дулаан хангах хэлбэрээр зохицуулсан.

Уурхай үйлдвэрийн дэргэд ахуйн болон бусад хог хаягдлыг хаях цэг, ОО-ыг байгуулан орчныг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч эмх цэгцтэй байлгах шалгалт ариутгалыг орон нутгаас гаргасан дүрэм журмыг тухайн хугацаанд нь мөрдлөг болгон ажилласан болно.

Уурхай, боловсруулах үйлдвэрт ажиллах инженер техникийн ажилчдыг “Дархан Молор-Эрдэнэ” ХХК-д ажиллаж буй дадлага туршлагатай инженер техникийн ажилчид болон мэргэжлийн баг бүрдүүлж ажилласан ба ажилчидыг аймаг, орон нутгаас бүрдүүлж ажилласан. Ингэснээр ажилгүйдлийг багасгах, мэргэжилтэй ажилчдыг сургаж, бэлтгэх ач холбогдолтой болно. Уурхай үйлдвэр нь хүчин чадал бага, бүтэц зохион байгуулалтын хувьд нүсэр биш учир уурхай болон боловсруулах үйлдвэрт 10 хүн ажилласнаас ИТА-2 ажилласан ба ажиллагсадад өдөр тутмын хөдөлмөр хамгаалалын зааварчлагыг тогтмол өгч, ажлын хувцас багаж хэрэгслээр бүрэн хангаж байсан бөгөөд энэ хугацаанд үйлдвэрлэлийн осол аваар гараагүй.

Уурхайн эдэлбэр газрын аюулгүй байдлыг хангах зорилгоор уурхайд явган хүн орох гарах аюулгүйн нулуу зам хийж ажилласан. Нийт ажиллагсадад ХААЭА талаар өдөр бүр зааварчилгаа өгч, ажилд гаргаж байснаас 10 хүнд сургалт явууллаа.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн мэдээ тайланг хүргүүлж байна..

“ХАРАА-3” УУРХАЙН 2023 ОНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Үзүүлэлтүүд		
1.	Аж ахуйн нэгжийн нэр		“Дархан молор эрдэнэ” ХХК
2.	Улсын бүртгэлийн дугаар		2016265
3.	Уурхайн нэр		Хараа-3
4.	Ордын нэр		Хараа-3
5.	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Дархан-Уул
6.		Сум/Дүүрэг	Хонгор сум
7.	Ашигт малтмалын төрөл		Элс
8.	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-001824
9.	Ашиглалт эхэлсэн огноо		2018
10.	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Дархан-Уул аймаг
11.		Сум/Дүүрэг	Хонгор сум
12.		Баг/Хороо	Салхит баг
13.		Гудамж/Байр	
14.		Шуудангийн хайрцаг	
15.		Утас	
16.		Факс	
17.		Гар утас	99110532, 88010111
18.		Электрон шуудан	
19.		Вэб хуудас	
20.	Захирлын хаяг	Нэр	
21.		Утас	88010111
22.		Факс	
23.		Гар утас	99110532
24.		Электрон шуудан	
25.	Нөөцийн тайлан хэлэлцсэн ЭБМЗ-ийн хурлын огноо, дүгнэлтийн дугаар		2023.08.30 , дугаарТ/23-12-04
26.	Нөөцийг бүртгэсэн шийдвэрийн огноо, дугаар		-
27.	Анхны нөөцийн хэмжээ		335506.8 м ³
29.	Ашиглах хугацаа		6 жил
30.	Жилийн хүчин чадал		50000м ³ элс
31.	Тухайн онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ		50000м ³ элс
32.	Дараа онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ		50000м ³ элс

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

“Хараа-3” уурхайн элс хайрга олборлох төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дурдсанаар газрын хэвлийг эвдэж өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, ангилан ялгаж угаах үйл ажиллагаагаар байгаль дэлхий эвдэрч бохирдохоос гадна тоос гэх мэт агаарт дэгдэх, шатах, тослох материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч эко системд их бага болон болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Бохирдлын эх үүсвэр нь шороон авто зам, бутлан ангилж угаах процесс, түлш шатахууны агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис (тоос, бохир ус, угаалгын нунтаг, саван, шампунь) зэрэг болно. Үйлдвэрлэл явуулж байгаа талбайгаас гадна хэрэгцээгүй зам харгуй гаргахгүй, гол замыг олон салаалуулахгүй байх арга хэмжээ авч, автомашин, механизмын засвар үйлчилгээ, гарсан хог хаягдал, асгарсан тос шатахууныг тусгай нүх, саванд хийж, газар усыг бохирдуулахгүй байх арга авч ажилласан.

Цаг агаарын хуурайшилтын үед гал түймрээс урьдчилан сэргийлэх үүднээс ил гал, түүдэг асаахыг хориглох, байгалийн түймрээс сэргийлэх санамж, зааврыг тухай бүр өгч ажиллуулж байсан.

Үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, газрын гүний усан орчин зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдлоо.

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Авдарыг нь уудалж ашигт малтмалыг нь авсан хэн бүхний, эх дэлхийгээ хайрлан хамгаалж эвдсэн орчноо нөхөн сэргээх, төлжихөд нь туслах нь бидний үүрэг зорилго бөгөөд зүйн хэрэг мөн болно. Байгаль орчны нөхөн сэргээлтийг, хуулийн хүрээнд, тогтоол шийдвэр, дүрэм журам, стандартыг үндэслэн уулын ажил болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Төсөвт өртөг 300.0 мян.төг. Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

5.1 Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Усны цогц бодлогын дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн болон хамгааллын бүс тогтоож, холбогдох дэглэмийг мөрдөн ажиллаж байна. Усыг тоос дарах зорилгоор ашигладаг. Хог хаягдал, бохир усыг

зөвшөөрөгдсөн талбай нүхэнд хийж, шатах тослох материалын асгаралт гаргаж хөрсний бохирдолгүй ажилласан нь гүний усанд нөлөөлөх нөлөөлөлгүй ажилласан болно.

Усны бохирдлыг багасгахын тулд хийсэн ажлууд

1.MNS900:2005–н шаарлага хангаж байгаа тул өөрийн гүний худгаас авч хэрэглэж байна.

2.Үйлдвэрийн орчны хог хаягдыг бороо үерийн усаар дамжин орж ирэхээс болгоомжилж цэвэрлэж байсан.

5.2 Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ

Ургамлан нөмрөг их хэмжээгээр утсанаас тухайн орчны агаарт өөрчлөлт орж, хуурайшилт бий болдог тул уурхайн явцын нөхөн сэргээлтийг хийхдээ биологийн нөхөн сэргээлийг аль болох боломжтой талбайг хамруулан хийсэн. Хуулж авсан өнгөн хөрсийг стандартын дагуу овоолго хийн хэлбэржүүлэн хадгалж, явцын нөхөн сэргээлтэнд хэрэглэж байна.

5.3 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

Хүрээлэн буй орчны хөрсний чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Тээвэрлэлтийн замын дагуу олон салаа зам бий болох	Тээвэрлэлтийг зориулалтын замын дагуу явахад хяналт тавих	Уурхайгаас тосгон хүртэл	Тогтмол хэрэгжиж байгаа.	Уурхайн орчин болон бусад үйл ажиллагаа явагдаж буй газарт хяналт тавьж ажиллаж байна. 2025 онд зөрчилгүй ажилласан.
2	Засвар үйлчилгээний явцад асгаралт гарч хөрс бохирдсон	Техникүүдэд хяналт тавих, асгаралтаас сэргийлэх, зориулалтын талбайд засвар үйлчилгээг хийлгэх, хяналт тавих	Техникүүдэд	Тогтмол хэрэгжиж байгаа.	2025онд асгаралт гаргасан зөрчил байхгүй. Зориулалтын засварын газарт үйлчилгээгээ хийлгэж байна.

Машин техникийн үйлчилгээ, засварын тусгай бэлтгэсэн талбайн зураг



5.4 Хог хаягдлын нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ

Ахуйн хаягдал болон үйлдвэрээс гарах бохир усыг хяналтгүй хаясны улмаас орчны хөрс, газрын доорхи ус, ургамалжилтанд дам нөлөөлдөг тул, аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байна.

.2025 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5

№	Хийгдэх ажлууд	Зардал, мян.төг		тайлбар
		төлөвлөгөө	биелэлт	
1	Ахуйн шингэн хаягдлыг тусгайлан доторлосон нүхэнд хуримтлуулан битүүмжлэх, ариутгал, устгал хийх	300.0	200.0	Бүгд биелсэн Ариутгал 2 удаа хийгдсэн
2	Хөрсийг ямар нэг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материалыг ил задгай асгахыг хориглох	Уурхайн ажлын хүрээнд		Энэ ажил хэвшсэн
3	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг эмх цэгцтэй төвлөрүүлэх нэг цэг байгуулах	200.0	-	Энэ ажил хийгдэж хэвшсэн

4	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Уурхайн ажлын хүрээнд	-	Энэ ажил хийгдэж хэвшсэн
5	Төв зам болон орд хүрэх зам дагуу, ордын талбай, үйлдвэр орчимд замыг тэмдэгжүүлэх	100	100,0	Энэ ажил хийгдсэн
6	Гал түймэр гарахаас сэргийлэх арга хэмжээг авч, түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, булан цэгүүд бэлтгэсэн байх.	100.0	150.0	Энэ ажил хийгдсэн
7	Элс олборлох, тээвэрлэх ажлыг геологи, уул техникийн нөхцөл, зураг төслийн дагуу хийх	Уулын ажлын хүрээнд	-	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн
8	Уурхай орчмын замын тоосыг усалгаа хийж бууруулах	Уулын ажлын хүрээнд	-	Төлөвлөгөөний дагуу хийдэг
	дүн	700	450,0	Бүгд биелсэн

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

6.1. Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь техникийн үе шат бүрэн дуусаж, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийдэг. Дархан-Уул аймгийн Хонгор сумын Салхит багт Эрхэт хайрхан уулын ард 1 га талбайд 12-13 сая төгрөгийн зардлаар мод тарьсан. Тус мод тарих байршлыг Дархан-Уул аймгийн Хонгор сумын Байгаль орчны байцаагч санал болгосон болно .

Нийт зардал 13.0 сая төгрөг зарцуулсан.

6.2. Техникийн нөхөн сэргээлт

Уурхайн нөхөн сэргээлтийн ажлаар ил уурхайг ашиглах явцад үүссэн орон зайд байрлах гадаад болон дотоод овоолгыг тэгшлэх, ухагдас, нүхийг хэлбэршүүлэн талбайг тэгшлэх, мөргөцгийн ханыг стандартын шаардлагад хүртэл налуулах, зэрэг техникийн нөхөн сэргээлтийн ажлын хийсэн.

Мөн уурхайн ойр орчмын зам, талбайд үүсэх хөрсний эвдрэл, гэмтлийг тэгшлэх, түрэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Техникийн нөхөн сэргээлтийг Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны 12 сарын 29-ний өдөр баталсан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ын дагуу гүйцэтгэж нөхөн сэргээлтэнд гарах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамгарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэсэн.

1 ачигч, 1 эксковатор, 1 бульдозер, 1 өөрөө буулгагч HOWO маркын автомашинаар 0.5 га талбайд дээр дурьдсан хэлбэрээр гүйцэтгэлээ. Ачигч болон бульдозер ашиглан эвдэрсэн талбайг түрж хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх ажлыг, нөхөн дүүргэлтийг автомашинаар зөөж тээвэрлэлээ.

. Үүнд:

-  Ашиглагдсан орон зайг дүүргэх
-  - Ашиглагдсан орон зай, ухашийг хэвгийжүүлэх , хэлбэржүүлэх
-  - Эвдэрсэн газрыг болон овоолгыг тэгшлэх гадагууг нь хэлбэржүүлэн тэгшлэх
-  - Овоолгын хажууг хэвгийжүүлэн дэвсгэжүүлэх
-  - Тэгшилсэн талбайг нягтаршуулах зэргээр хийлээ.
-  - Хөрс хуулалттай холбоотой үүссэн овон товон гадаргууг нь ерөнхийд нь сийрүүлэн тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуутай ойртуулан хэлбэршүүлэх, ажилгаанууд хийгдэж , дараа нь нарийвчлан хэлбэржүүлж өнгөлөн тэгшлэх ажиллагааг хийлээ.

Нөхөн сэргээлтийн ажилд дараах стандарт болон заавруудын шаардлагыг хангаж ажилласан:

- MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 4915:2000 Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, Хадгалах. Техникийн шаардлага
- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах.Техникийн шаардлага
- MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу.Техникийн шаардлага

2025 оны нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал

Хүснэгт №6

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Ашиглагдах техник, тайлбар	Нэгж ажлын зардал, төг	Нийт зардал, мян.төг
1. Бэлтгэл ажлын зардал						
2. Техникийн нөхөн сэргээлтийн ажил						
	Ил уурхай, дотоод овоолго					
1	Дотоод овоолгыг түрж тэгшлэх, хэвгийжүүлэх	М²	5000	Утгуурт ачигч	2500	15000.0
3	Бусад эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	М²	-	-	-	
Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн		мян.төг				15000.0
3. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал						
1	Мод бургас	ш	1000	-	13000	10000.0
	Үрсэлгээнд	-				
	Тарих суулгах бусад зардал					3000.0
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын дүн		мян.төг				13000.0
Нийт						28000.0

7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Энэхүү ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Дархан-Уул аймгийн Байгаль орчны газарт Зулзага зусланд мод тарих зардал болох 10.0 сая төгрөг өгсөн.
- Дархан-Уул аймгийн Хонгор сумын Байгаль орчны газарт 10 сая төгрөгийг өгсөн.

Нийт зардал 20.0 сая төгрөг зарцуулсан

8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

10. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хүрээнд хамааралгүй. Учир нь уурхайд химийн бодис хэрэглэдэггүй.

11. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт №7

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	“Дархан молор эрдэнэ” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Цаг агаарын мэдээг 7 хоног бүр гарган нийт ажилчдад танилцуулан, арга хэмжээг авч ажилласан.
2	Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	“Дархан молор эрдэнэ” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Хийгээгүй
3		Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	“Дархан молор эрдэнэ” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн.	Шаардлагатай цэгүүдэд галын хор, санамж бичиг галын сарааг байршуулсан.
4	Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	“Дархан молор эрдэнэ” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Ажил эхлэхийн өмнө нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллаж байна. АА-ны зөрчилгүй ажилласан.
6		Ажиллагсдын хөдөлмөр	“Дархан молор	Бүрэн хэрэгжсэн	Нийт ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг

	үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	хамгааллын хувцас хэрэгслээр хангах	эрдэнэ” ХХК-ний ажилчид		хуваарилан өгч, шаардлагатай нэг бүрийг хэрэгслийг өгч ажилласан.
7		Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	“Дархан молор эрдэнэ” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Тогтмол хяналт тавьж ажилласан. 2025 онд гаргасан зөрчилгүй.

Шаардлагатай цэгүүдэд галын хор, санамж бичиг галын сарааг байршуулсан байдал



12. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Энэ ажлын хүрээнд хүснэгт №7-д тусгагдсан ба уурхай дээр хог агуулах цэг байгуулсан, төлөвлөгөөний биелэлт хангалттай гэж үзэж байна. . Үйлдвэрийн объект бүрт хог хаягдлыг ангилан ялгаж хаях зориулалтын хогийн сав ба хатуу хог хаягдлыг түр байршуулах цэг байгуулсан. Үүгээр үйлдвэрийн талбайд хатуу хог хаягдалгүй, хог хаягдал тархалтыг бүрэн хязгаарласан, эмх цэгцтэй байх нөхцлийг бүрдүүлж чадна. Хатуу хог хаягдалыг зөвхөн сумын захиргаанаас зөвшөөрсөн хогийн цэгт тээвэрлэн зайлуулсан.

Хүснэгт №8

д/д	Мэдээллийн төрөл	Утга
1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /кг/	хамаарахгүй
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	хамаарахгүй
2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /кг/ агуулах байгаа эсэх	хамаарахгүй
	2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /кг/ агуулах байгаа эсэх	
3	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /кг/ - Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ - Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ - Аюултай хог хаягдал	150,0 хамаарахгүй
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний зарцуулсан төсөв	500000 төгрөг

13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

БОМТ-ийн хэрэгжилтийг хангуулахад компаний дотоод нэгжүүд дараах хэлбэрээр оролцсон.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан нэгж үйлдвэрийн горимын мөрдөлтөнд хяналт тавьж ажилласан.
- Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн БОМТ-ийн хэрэгжилтийг хангуулахаас гадна тус жагсаалтанд дурьдсан гүйцэтгэлийг хамаарах ажилтнуудад зөвлөмжийг өгч ажилласан.

Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд Хараа-3 элсний ордыг ашиглах төслийн ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх төсөл, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажилласан.

- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг компаний захирал уурхайн дарга, инженерүүд хариуцан гүйцэтгэх бөгөөд жил

бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар ажиллав.

- Нөхөн сэргээлт болон байгаль орчныг хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэсэн бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгнө.
- Компаны удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.

Удирдлага зохион байгуулалтын зардал

Хүснэгт 9

№	Хийгдэх ажлууд	Зардал, мян.төг	тайлбар
1	Байгаль орчныг хамгаалах, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг өөрийн ажиллагсдын дунд зохион байгуулах.	250,0	биелсэн
2	Уурхайн ажилчид мөн ачигчидыг тусгай амны хошуувчаар хангасан.	500.0	Зардал гараагүй
3	Ой, хээрийн түймрээс сэргийлэх, унтраах хэрэгслээр бүрэн хангах, ажиллагсдыг түймэр унтраах арга барилд сургах, гал түймэр гарсан тохиолдолд шуурхай унтраах арга хэмжээ авах. Байгаль хамгаалагчдад туслах.	-	Зардал гараагүй
	дүн	750.0	

14. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт

Энэ ажлын хүрээнд дараах ажлууд зохион байгуулагдсан.

Төсөл хэрэгжүүлэгч “Дархан Молор Эрдэнэ ” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад

тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 10

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах,	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг	-
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн	Тайланг хүлээн авсан актыг	12-р сар	-	-


15. Дүгнэлт

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв, биелэлтийг Хүснэгт №8-д үзүүлэв.


Хүснэгт №11

д/д	Мэдээллийн төрөл	мян. төг биелэлт	тайлбар
1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	50000.0	
	2. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	500.0	
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	300.0	
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, /	15000.0	
	4. Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /биологийн/	13000.0	
	5. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	20000	
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-	Зардал гаргаагүй
	7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх уд ирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	750.0	
2	1. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-	хамааралгүй
3	1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төсөв	450.0	

ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ




ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ




ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



МОН ТАРЬЖ БУЙ ЗУРАГ



МОН ТАРЬЖ БУЙ ЗУРАГ



МОД ТАРЬЖ БУЙ ЗУРАГ



